

Эмийг хэрхэн аюулгүйгээр хэрэглэвэл зохих вэ?

- Эмийг шошгон дээрх зааврын дагуу хэрэглэх.
- Эмийг хэзээ, ямар хэмжээгээр хэрэглэх талаар мэдэж авах.
- Эмийн идэвхитэй найрлагыг мэдэж авах.
- Хэрэглэж буй эмнүүдийнхээ жагсаалттай байх нь танд өөрт болон таны эмч, эмзүйчид эмийн хэрэглээг тань хянахад тус болно.

Идэвхитэй найрлага гэж юу вэ (active ingredient)?

- Идэвхитэй найрлага нь тухайн эмийн нөлөө үйлчилгээг үзүүлэх үндсэн бүрэлдэхүүн юм.
- Эмийн шошгон дээрх мэдээллийг шалгаж байх нь харагдах байдлаараа ялгаатай боловч, идэвхитэй найрлага нь ижил эмүүдийг нэг зэрэг хэрэглэхээс сэргийлнэ.
- Таны уух эмнүүд дотор идэвхитэй найрлага нь ижил нэгээс олон эм байвал өөрийн эмч эсвэл эмзүйчтэйгээ холбогдоорой.

Идэвхитэй найрлагыг хэрхэн олж мэдэх вэ?

- Өөрийн эмч эсвэл эмзүйчээс асуух.
- Идэвхитэй найрлага нь эмийн шошгон дээр бичигдсэн байдаг.
- Хэрэглэж буй эмнүүдийнхээ идэвхитэй найрлагыг бичиж тэмдэглэж байх нь зүйтэй. Эмнүүдийнхээ зургийг нь авах эсвэл цаасан дээр эмийн жагсаалт гарган хадгалж болно.

Эмэнд зарцуулах мөнгөө хэрхэн хэмнэх вэ?

- Эмнүүд янз бүрийн нэртэй байж болно – эм үйлдвэрлэгчид тухайн эмний идэвхитэй найрлагын нэр болон тэрхүү эмний брэнд болгон нэрлэсэн нэрийг хэрэглэдэг. (оригинал брэнд нэр эсвэл ерөнхий брэнд нэр гэж ялгаж нэрлэдэг).
- Идэвхитэй найрлага нь ижил боловч ерөнхий брэндийн эм нь оригинал брэндийн эмнээс ихэвчлэн арай хямд байдаг.
- Таны эмч эсвэл эмзүйч таны мөнгийг хэмнэх зорилгоор ерөнхий брэндийн эмийг санал болгож болох юм.

Өвчтэй байгаа гэр бүлийн гишүүд эсвэл найзууддаа өөрийн хэрэглэж буй эмнээс хуваалцаж болох уу?

- Үгүй, таны эм зөвхөн танд зориулагдсан.
- Хэрвээ таны эмийг гэр бүлийн гишүүн эсвэл найз чинь хэрэглэвэл тэдэнд аюултай байж болзошгүй.

Ковид-19 (COVID-19) цар тахлын үеэр эмээ хэрхэн зохицуулах вэ?

- Эмнүүдээ эмчийн бичсэн жорын дагуу хэрэглээрэй.
- Өөрийн тогтмол хэрэглэдэг, жороор олгогддог эмнүүдээс нэг сарын нөөц бэлдсэн байвал зохино.
- Хэрвээ эмнэлэг рүү явах хэрэгтэй бол ууж буй эмнүүдээ эсвэл эмийн жагсаалтаа биедээ авч яваарай.

Эмнийхээ талаар хэнээс зөвөлгөө авч болох вэ?

- Өөрийн эмч эсвэл эмзүйчтэйгээ холбогдох. Танд хэлмэрч хэрэгтэй бол эмчдээ хэлээрэй.
- **Эмийн Лавлах (Medicines Line) 1300 633 424** руу залгах. Үнэ, төлбөргүй хэлмэрч авахыг хүсвэл **Орчуулга болон Хэлмэрчийн Үйлчилгээ (Translating and Interpreting Service, TIS) 131 450** руу залган ямар хэлээр ярьдагаа хэлж Эмийн Лавлах үйлчилгээтэй холбож өгөхийг хүсээрэй.



Идэвхитэй найрлага

